



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/347

Мандалговь

Ц.Бадамсэдэд урамшуулал  
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, аймгийн Засаг даргын 2017 оны А/251 дүгээр захирамжаар батлагдсан "Урамшууллын жишиг тогтоох журам"-ын 2 дугаар бүлгийн 2.2 дах заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Эрдэнэдалай сумын уугуул Цэрэндоржийн Бадамсэд нь Монгол Улсын Хүний Гавьяат эмч" цол хүртсэн тул 400000 (дөрвөн зуун мянга) төгрөгийн урамшуулал олгож, аймгийн Засаг даргын "Хүндэт өргөмжлөл"-өөр урамшуулсугай.

Хоёр. Мөнгөн шагналд 400000 (дөрвөн зуун мянга), Хүндэт өргөмжлөл хэвлүүлэхэд 35000 (гучин таван мянга), нийт 435000 (дөрвөн зуун гучин таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

480010123